



2019 оны 03 сарын 07

Дугаар А/150

Дүрэм

Газар эзэмшүүлэх дуудлага
худалдааг дахин зохион байгуулах
тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Газрын тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журамын 10.1, аймгийн Засаг даргын 2019 оны А/29 дүгээр захирамжийн 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын 2018 оны А/627 дугаар захирамжаар газар эзэмшүүлэх дуудлага худалдаа явуулсан 44 байршлаас газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журмын 10.1.2 дахь заалтын дагуу дуудлага худалдааг дахин явуулах нөхцөл бүрдсэн Баруун Зуунмод 6-р багийн 1 байршилд амины орон сууцны зориулалтаар 100 м² газар эзэмшүүлэх дахин дуудлага худалдааг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсугай.

2. Дуудлага худалдааны анхны үнэ, дэнчинг өмнөх дуудлага худалдааны тогтоосон үнийг мөрдөж ажилсугай.

3. Батлагдсан төлөвлөлтийн дагуу газар эзэмшүүлэх дахин дуудлага худалдааг танхимын хэлбэрээр явуулахыг Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/ нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Д.Мөнхбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ